

**МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ**

202. оны ... дүгээр
сарын ... өдөр

Дугаар №

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 77 дугаар зүйлийн 77.5 дахь хэсэг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 9¹ дүгээр зүйлийн 9^{1.2} дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ажиллах хүч нийлүүлэх үйлчилгээ үзүүлэх аж ахуй нэгж, байгууллагад тавигдах шаардлага, бүртгэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга /Л.Дашдэмбэрэл/-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд арга зүйн дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Дамбий/-т үүрэг болгосугай.

ГАРЫН ҮСЭГ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
202. оны дүгээр сарын-ны өдрийн
..... тоот тушаалын хавсралт

АЖИЛЛАХ ХҮЧ НИЙЛҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ АЖ АХУЙ НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД ТАВИГДАХ ШААРДЛАГА, БҮРТГЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 76, 77 дугаар зүйл, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 9¹ дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах, ажиллах хүч нийлүүлэх үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгж байгууллагад тавигдах шаардлага, тэдгээрийг шалгуур үзүүлэлтийн дагуу бүртгэх үйл ажиллагааг холбогдох бусад хууль, тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2. Ажиллах хүч нийлүүлэх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд /цаашид “ажиллах хүч нийлүүлэгч” гэх/-ийг бүртгэх үйл ажиллагааг аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага нь нээлттэй, ил тод, шударга байх зарчмыг баримтлан зохион байгуулна.
- 1.3. Бүртгэх үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагын цахим хуудаст холбогдох мэдээллийг тогтмол байршуулна.

Хоёр. Ажиллах хүч нийлүүлэх үйлчилгээ үзүүлэх аж ахуй нэгж, байгууллагад тавигдах шаардлага

- 2.1. Ажиллах хүч нийлүүлэгч нь дараах шаардлагыг хангасан байна.
 - 2.1.1. Монгол улсад бүртгэлтэй үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд байх;
 - 2.1.2. Татварын байгууллагад бүртгэлтэй, татварын өргүй байх;
 - 2.1.3. Нийгмийн даатгалын байгууллагад бүртгэлтэй, нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй байх;
 - 2.1.4. Ажиллах хүч нийлүүлэх хүчинтэй гэрээтэй байх;
 - 2.1.5. Ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээтэй байх;
 - 2.1.6. Ажиллах хүч нийлүүлэгч байгууллага хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны ажилтантай байна.

Гурав. Ажиллах хүч нийлүүлэх үйлчилгээ үзүүлэх аж ахуй нэгж, байгууллагыг бүртгэж, гэрчилгээ олгох, хүчингүй болгох

- 3.1. Аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага холбогдох ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн ажлын 10 хоногт багтаан ажиллах хүч нийлүүлэгчийг бүртгэж, гэрчилгээ олгоно.
- 3.2. Аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагын даргын тушаалаар ажиллах хүч нийлүүлэх үйлчилгээ үзүүлэх аж ахуй нэгж,

байгууллагыг бүртгэж, гэрчилгээ олгохтой холбоотой асуудлыг судлаж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулна.

3.3. Ажлын хэсэг нь аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий 5 хүний бүрэлдэхүүнтэй байна.

3.4. Ажлын хэсгийн хуралд холбогдох мэргэжлийн хүмүүсийг урьж, санал хэлэх эрхтэйгээр оролцуулж болно.

3.5. Ажлын хэсгийн гишүүдийн 75-аас дээш хувь нь хуралд оролцсон тохиолдолд хурлыг хүчин төгөлдөр болсонд тооцно.

3.6. Ажлын хэсгийн хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно.

3.7. Ажлын хэсэг нь баримт бичиг хүлээж авснаас хойш ажлын 10 хоногийн дотор хуралдаж, гэрчилгээ олгох талаар дүгнэлт гаргана.

3.8. Шаардлага хангасан баримт бичиг бүрдүүлсэн хуулийн этгээдэд 2 жилийн хугацаатайгаар гэрчилгээ олгоно.

3.9. Ажиллах хүч нийлүүлэгчийн албан хүсэлт, үйл ажиллагаа явуулсан, үйлчлүүлэгч аж ахуй нэгж, ажилтанаас гомдол санал гаргасан эсэхийг харгалзан үзэж гэрчилгээг 1 жилийн хугацаатай сунгаж болно.

3.10. Гэрчилгээний загварыг Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

3.11. Ажиллах хүч нийлүүлэгчийн бүртгэлийг дараах тохиолдолд хүчингүй болгоно:

3.11.1. Ажиллах хүч нийлүүлэгч нь өөрөө хүсэлт гаргасан;

3.11.2. Ажиллах хүч нийлүүлэгч татан буугдсан;

3.11.3. Иргэнийг хуулиар хориглосон ажилд нийлүүлсэн болон нийлүүлэхийг оролдсон нь нотлогдсон;

3.11.4. Ажиллах хүч нийлүүлсэний төлбөрийг ажилтнаас шууд ба шууд бусаар авсан;

3.11.5. Хуурамч бичиг, баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;

3.11.6. Ажилтны хөдөлмөрлөх эрхийг зөрчсөн талаарх гомдол холбогдох хууль, хяналтын байгууллагаар тогтоогдсон;

3.11.7. Үйл ажиллагааны явцад гарсан зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй.

Дөрөв. Ажлын хэсгийн үйл ажиллагаа

4.1. Ажлын хэсэг нь дараах ажлыг хийж гүйцэтгэнэ.

4.1.1. Ажиллах хүч нийлүүлэгчид хэрхэн бүртгүүлэх талаар зөвлөгөө мэдээлэл өгөх, шаардлагатай мэдээ мэдээлэл, судалгааг хүсэлт гаргасан хуулийн этгээдээс гаргуулж авах;

4.1.2. Бүртгэх үйл ажиллагаатай холбоотой гарсан аливаа өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх;

4.1.3. Бүртгэлийн гэрчилгээ олгох, сунгах, хүчингүй болгох дүгнэлт гаргах;

4.1.4. Шаардлагатай тохиолдолд бүртгүүлэх хүсэлт гаргасан ажиллах хүч нийлүүлэгчийн үйл ажиллагаатай нь танилцах, хяналт-шинжилгээ хийх, дүгнэлт гаргах;

4.1.5. Бүртгэх үйл ажиллагаатай холбоотой гарсан дүрэм, журмыг боловсронгуй болгох талаар санал дүгнэлт боловсруулах, эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

4.1.6. Бүртгэж гэрчилгээ олгох үйл ажиллагааг нээлттэй хурлаар хэлэлцэж, ажлын хэсгийн гишүүдийн ил санал хураалтаар шийдвэрлэх;

4.1.7. Ажлын хэсгийн хурлаар хэлэлцсэн асуудлаар тэмдэглэл хөтөлж, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах;

4.1.8. Бүртгэх үйл ажиллагааг зохион байгуулсан ажлын хэсгийн шийдвэр, тайлан мэдээ, санал дүгнэлтийг аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ.

Тав. Ажиллах хүч нийлүүлэгчийн бүрдүүлэх баримт бичиг

5.1. Энэхүү журмын 2.1-д заасан шаардлагыг хангасан аж ахуй нэгж, байгууллага нь дараах баримт бичгийг бүрдүүлэн аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад бүртгүүлнэ.

5.1.1. Албан хүсэлт;

5.1.2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, эсхүл лавлагаа;

5.1.3. Байгууллагын үйл ажиллагааны талаарх товч танилцуулга;

5.1.4. Байгууллагын удирдах ажилтны анкет;

5.1.5. Хүлээн авагчтай байгуулсан ажиллах хүч нийлүүлэх үйлчилгээ үзүүлэх гэрээ;

5.1.6. Ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ;

5.1.7. Татварын байгууллагын лавлагаа;

5.1.8. Нийгмийн даатгалын байгууллагын лавлагаа;

5.1.9. Ажиллах хүч нийлүүлэгч байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй харицсан боловсон хүчний анкет, диплом, гэрчилгээний хуулбар.

5.2. Баримт бичгийн бүрдлийг бүрэн хангаж ирүүлнэ /Уншигдахгүй, гаргагдаагүй материалыг ирүүлээгүйд тооцно/.

5.3. Бүрдүүлэх баримт бичгийн аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд татгалзах, бүртгэж гэрчилгээ олгохгүй байх үндэслэл болно.

Зургаа. Ажиллах хүч нийлүүлэх үйлчилгээ үзүүлэх аж ахуй нэгж, байгууллагын үүрэг

6.1. Ажиллах хүч нийлүүлэгч нь хөдөлмөрийн гэрээ бүхий ажилтнаа өөр ажил олгогчид ажиллуулахдаа хүлээн авагч талтай ажиллах хүч нийлүүлэх гэрээг бичгээр байгуулсаны үндсэн дээр ажиллуулна.

6.2. Ажиллах хүч нийлүүлэгч нь Хөдөлмөрийн тухай хуулийн 76.2-д заасан нөхцөлд хүлээн авагчид ажиллах хүч нийлүүлнэ.

6.3. Ажиллах хүч нийлүүлэгч нь Хөдөлмөрийн тухай хуулийн 76.6, 76.8-76.10, 77.1-77.3-д заасан үүргийг хүлээнэ.

6.4. Ажиллах хүч нийлүүлэх гэрээгээр ажиллаж буй ажилтны хувь хүний мэдээллийг хадгална.

6.5. Ажиллах хүч нийлүүлэгч нь хүлээн авагч талтай хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг хангах, болзошгүй тохиолдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас ажилтанд учирсан хохирлыг нөхөн төлөх, амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулах зэрэгт зайлшгүй шаардагдах хөрөнгө болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгасан байна.

6.6. Ажиллах хүч нийлүүлэгч байгууллага нь хүлээн авагч байгууллага, ажил горилогч иргэдийн судалгаа, мэдээллийн нэгдсэн санг үүсгэнэ.

6.7. Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй бодлого, төлөвлөлттэй уялдуулан, үйл ажиллагаагаа зохион байгуулна.

6.8. Хуулиар хориглосон үйл ажиллагаанд ажиллах хүч нийлүүлэхийг хориглоно.

Долоо. Мэдээ, тайлан

7.1. Аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага нь ажиллах хүч нийлүүлэх үйлчилгээ үзүүлэх аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагааны улирлын мэдээ, тайланг дараа сарын 10-ны дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдээлж, тайлагнана.

7.2. Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь үйл ажиллагааны улирлын мэдээ, тайланг дараа сарын 14-ний дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдээлж, тайлагнана.

Найм. Бусад

8.1. Энэхүү журмын 3.11.3-3.11.7-д заасан зөрчил илэрсэн тохиолдолд бүртгэлийн гэрчилгээг 2 жилийн хугацаанд дахин сунгаж, олгохыг хориглоно.

8.2. Журмын хэрэгжилт, ажиллах хүч нийлүүлэх үйлчилгээ үзүүлэх аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, холбогдох бусад байгууллагаас хяналт тавих бөгөөд хөндлөнгийн байгууллагаар аудит хийлгэж болно. Энэхүү журмыг зөрчигчдөд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

8.3. Ажиллах хүч нийлүүлэх үйлчилгээ үзүүлэх аж ахуй нэгж, байгууллагыг бүртгэх, бүртгэлийг хүчингүй болгохтой холбоотой гомдол, маргааныг Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад гаргах ба шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.